

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар хуралдааны тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН нь: Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын талаарх танилцуулга

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөлтэй танилцаад, Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулж, холбогдох журмын дагуу энэ оны 3 дугаар улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Зам, тээврийн сайд /М.Зоригт/, хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагаанд хууль эрх зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр хангаж ажиллахыг Хууль зүйн сайд /Д.Дорлигжав/-д тус тус даалгав” гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн
найруулгын үзэл баримтлалын
төслийн тухай

Далай ашиглах тухай хуулийн зорилт, үйлчлэх хүрээ, зохицуулалт нь одоогийн нөхцөл шаардлагад нийцэхгүй, агуулга, найруулгын хувьд учир дутагдалтай байдлыг харгалзан үзэж, шинэчилсэн найруулга хийх явцад үүссэн судалгааны ажлын үр дүнд үндэслэн энэхүү хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулаад байна.

Далайн ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 18 төрлийн шинэ нэр томъёо тайлбарлагдах бөгөөд эдгээр нэр томъёоны агуулга, зохицуулалтыг хуульчлан оруулна. Далай ашиглах тухай хуульд 8 төрлийн нэр томъёо байсан ба эдгээрийн тайлбар нь учир дутагдалтай, зохицуулалт нь хуулиндаа байгаагүй юм.

Энэ хуулийн төслийн зорилт, үйлчлэх хүрээ, зохицуулалт нь Далай ашиглах тухай хуулиас илүү өргөн хүрээтэй, зөв, оновчтой, манай улсын онцлогт зохицуулсан, хэрэгжүүлэх боломжоор хангагдсан, хариуцлагын тогтолцоог эрх үүргээр зохицуулан тодорхойлсон, салбарын эрх зүйн болон эдийн засгийн маргаан зөрчлийг шийдвэрлэхэд чиглэгдэнэ.

Хуулийн төсөл нь үндсэн зургаан бүлэг, хорин зүйлтэй бөгөөд нийтлэг үндэслэл буюу нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, далай ашиглах хууль, тогтоомж, үйлчлэх хүрээ, нэр, томъёонуудыг тодорхойлно.

Хоёрдугаар бүлэгт далай ашиглах үйл ажиллагааны талаархи төрийн болон төрийн бус байгууллагуудын эрх үүргийн талаар тусгаж, Улсын Их хурал, Засгийн газар, холбогдох яамдуудын энэ салбарт хамтран ажиллах уялдаа холбоо, Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хөлөг онгоцоор далайн тээвэр хийх, далайд загас агнуур эрхлэх, далайн баялаг олборлох, далайд судалгаа шинжилгээ хийх зэрэг далай ашиглах үйл ажиллагаа эрхлэх асуудлуудыг хэрхэн зохион байгуулж, хэрэгжүүлэхийг тусгана.

Гуравдугаар бүлэгт далай ашиглах үйл ажиллагааны гол үндсэн тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хамаарах асуудлуудын талаар тусгаж, энэ үйл ажиллагаанд оролцогч этгээдүүдийн хоорондын харилцааг зохицуулна.

Дөрөвдүгээр бүлэгт хөлөг онгоц бүртгэхтэй холбогдсон бүхий л харилцаа, зохицуулалтын талаар тусгана.

Тавдугаар бүлэгт хөлөг онгоц, түүний баг, хөлөг онгоцны аюулгүй ажиллагаа, далайг бохирдуулахаас сэргийлэх буюу хөлөг онгоц, болон багийн гишүүдэд тавигдах шаардлага, ахмадын эрх, үүрэг, хөлөг онгоцонд аюул учирсан үед зохицуулах харилцаа, тусламж үзүүлэх, хөлөг онгоцыг орхих, хариуцлагатай холбогдох далайн мэдэгдлийн тухай, хөлөг онгоцон дээр гэмт хэрэг гарах, хүн төрөх, нас барахад үүсэхтэй холбогдсон харилцааг тодорхойлно.

Төгсгөлийн зургаадугаар бүлэгт далай ашиглах тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг зааж өгнө.

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

БАТЛАВ:
ХУУЛЬ ЗҮЙН САЙД

БАТЛАВ:
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД

Д.ДОРЛИГЖАВ

М.ЗОРИГТ

**“ДАЛАЙ АШИГЛАХ ТУХАЙ” ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагын талаар

Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Далайд гарцгүй орны транзит худалдааны тухай” 1965 оны конвенци, “Далайн эрх зүйн байдлын тухай” 1982 оны конвенци, “Их далайн тухай” 1958 оны конвенци, Олон Улсын Далайн Байгууллагын 1948 оны конвенциудад манай улс тус тус нэгдэн орсон билээ.

Мөн Далайн гарцгүй улсуудын далбаагаа мандуулах эрхийг хүлээн зөвшөөрсөн тунхаглалд 1976 оны 7 дугаар сарын 27-ны өдөр БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 170 дугаар зарлиг гарч нэгдэн орсон байна.

Эдгээр конвенциудад их далай нь эргийн улс, далайд гарцгүй улсуудыг оролцуулан бүх улсад нээлттэй байна гэж заасан байдгаас гадна далайд гарцгүй улсуудын далайд гарах, түүнээс буцаж гарах, чөлөөтэй дамжин өнгөрөх эрх болон далай тэнгисийн бүхий л бүсэд тээвэрлэлт хийх, далайн баялаг ашиглах, тухайн улсын төрийн далбаан дор далайн тээвэр эрхлэх талаар тодорхой заасан байдаг.

“Далайн эрх зүйн байдлын тухай” НҮБ-ын конвенцид 1996 онд нэгдэн орсны дараа Монгол Улсын Засгийн газраас “Их далайг ашиглах талаар авах зарим арга хэмжээний тухай” 1996 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 316 дугаар тогтоолыг гаргаж уг тогтоолоор хөлөг онгоцны бүртгэл хийх эхлэлийг тавьж, Улаанбаатар хотыг бүртгэлийн боомт хот хэмээн зарласан бөгөөд энэ чиглэлээр ажиллах хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, их далайд аж ахуйн үйл ажиллагаа явуулах, холбогдох бодлогын баримт бичиг боловсруулахыг холбогдох яамдуудад даалгасан юм.

Улмаар 1999 оны 5 дугаар сарын 28-нд “Далай ашиглах тухай” хуулийг УИХ-аар баталсан бөгөөд 2001 оны 1 дүгээр сарын 31-ний Засгийн газрын хуралдаанаар хөлөг онгоцны бүртгэлийг хэрэгжүүлэхийг Дэд бүтцийн сайдад, далайн баялаг ашиглах үйл ажиллагааг хойшлуулан зөвхөн дотооддоо загас барих үйл ажиллагааг эрхлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайдад тус тус даалгаж байлаа.

Үүнтэй холбогдуулан 2001 оны 11 дүгээр сард тухайн үеийн Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Автотээврийн газар, Сингапур Улсын нэгэн хувийн “Маритайм чейн” гэдэг компанитай хамтарсан компани байгуулах тухай хэлэлцээр хийж “Монголын хөлөг онгоцны бүртгэл” компанийг байгуулсныг Засгийн газрын 2002 оны 11 дүгээр сарын 13-ны

хуралдаанд танилцуулан улмаар 2003 оны 2 дугаар сарын 12-ны өдөр хөлөг онгоц бүртгэх эрхийг 5 жилийн хугацаатай өгч үйл ажиллагааг нь эхлүүлсэн.

Энэ үеэс хойш зөвхөн хөлөг онгоц бүртгэх үйл ажиллагааг Сингапур Улсын хувийн компаниудтай хамтран хийж ирсэн бөгөөд тухайн үед манай улсад энэ салбарт ажиллах туршлага, мэргэжлийн боловсон хүчин хангалтгүй байсан билээ.

2007 оны 11 дүгээр сард “Далай ашиглах тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны дараа тус хуулийн 8¹-д заасны дагуу тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх ажлын хүрээнд Далайн захиргаа гэдэг байгууллага байгуулан ажиллуулж эхэлсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан эрх зүйн статусгүй боловч энэ байгууллагыг Төрийн өмчит Улсын үйлдвэрийн газар юм гэж Хууль зүй, дотоод хэргийн яамнаас тодорхойлсон байдаг.

Олон улсын практикт болон олон улсын гэрээ, конвенцид заасан жишгээр далайн асуудал эрхэлсэн захиргаа нь Засгийн газрынхаа өмнөөс олон улсын өмнө үүрэг, хариуцлага хүлээсэн худалдааны далайн тээвэр, далай ашиглах бүхий л үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж ажилладаг төрийн захиргааны байгууллага байдаг.

Далай ашиглах тухай хуулийн зорилт, үйлчлэх хүрээ, зохицуулалт нь одоогийн нөхцөл шаардлагад нийцэхгүй, агуулга, найруулгын хувьд учир дутагдалтай байдлыг харгалзан үзэж, хуулийг сайжруулан боловсруулахаар хийгдсэн судалгааны ажлын үр дүнд үндэслэн энэхүү хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулаад байна.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 18 төрлийн шинэ нэр томъёог тайлбарлан оруулахаар зорьсон ба эдгээр нэр томъёоны агуулга, зохицуулалтыг хуульчлан оруулах юм. Далай ашиглах тухай хуульд 8 төрлийн нэр томъёо байсан ба эдгээрийн тайлбар нь учир дутагдалтай, зохицуулалт нь хуулиндаа байгаагүй юм.

Шиэнчилсэн найруулгын төслийн зорилт, үйлчлэх хүрээ, зохицуулалт нь Далай ашиглах тухай хуулиас илүү өргөн хүрээтэй, зөв, оновчтой, манай улсын онцлогт зохицуулсан, хэрэгжүүлэх боломжоор хангагдсан, хариуцлагын тогтолцоог эрх үүргээр зохицуулан тодорхойлсон, салбарын эрх зүйн болон эдийн засгийн маргаан зөрчлийг шийдвэрлэхэд чиглэгдэх ёстой.

Монгол Улс далайд гарцгүй орны хувьд бусад далайн эрэг бүхий орнуудын нэгэн адил конвенциор олгогдсон эрхээ эдэлж, гадаад далайд гарч өөрийн улсын экспортын болон импортын бүх төрлийн ачаа барааг хөлөг онгоцоор тээвэрлэн далайн олон улсын худалдаа, тээврийн үйл ажиллагаанд оролцох, далайн баялагийг ашиглах зорилго тавьж байгаа энэ үед хууль, эрх зүйн маш оновчтой, таатай орчинг бүрдүүлэх чухал хэрэгцээ бий болоод байгаа нь энэхүү хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага болж байна.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээг тодорхойлох талаар

Хуулийн төсөл нь үндсэн зургаан бүлэг, хорин зүйлтэй бөгөөд нийтлэг үндэслэл буюу нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, далай ашиглах хууль, тогтоомж, үйлчлэх хүрээ, нэр, томъёонуудыг тодорхойлно.

Хоёрдугаар бүлэгт далай ашиглах талаархи төрийн болон төрийн бус байгууллагуудын эрх үүргийн талаар тусгаж, Улсын Их хурал, Засгийн газар, холбогдох яамдуудын энэ салбарт

хамтран ажиллах уялдаа холбоо, Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хөлөг онгоцоор далайн тээвэр хийх, далайд загас агнуур эрхлэх, далайн баялаг олборлох, далайд судалгаа шинжилгээ хийх, хөлөг онгоц бүртгэх зэрэг далай ашиглах үйл ажиллагаа эрхлэх асуудлуудыг хэрхэн зохион байгуулж, хэрэгжүүлэхийг тусгана.

Гуравдугаар бүлэгт далайн тээврийн үйл ажиллагаанд хамаарах асуудлуудын талаар тусгаж, энэ үйл ажиллагаанд оролцогч этгээдүүдийн хоорондын харилцааг зохицуулсан гэрээний тухай тусгана.

Дөрөвдүгээр бүлэгт хөлөг онгоц бүртгэхтэй холбогдсон бүхий л харилцаа, зохицуулалтын талаар тусгана.

Тавдугаар бүлэгт хөлөг онгоц, түүний баг, хөлөг онгоцны аюулгүй ажиллагаа, далайг бохирдуулахаас сэргийлэх буюу хөлөг онгоц, болон багийн гишүүдэд тавигдах шаардлага, ахмадын эрх, үүрэг, хөлөг онгоцонд аюул учирсан үед зохицуулах харилцаа, тусламж үзүүлэх, хөлөг онгоцыг орхих, хариуцлагатай холбогдох далайн мэдэгдлийн тухай, хөлөг онгоцон дээр гэмт хэрэг гарах, хүн төрөх, нас барахад үүсэхтэй холбогдсон харилцааг тодорхойлно.

Төгсгөлийн зургаадугаар бүлэгт далай ашиглах тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг заана.

Хуулийн төсөлд Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага далай ашиглах үйл ажиллагааг бүхий л төрөл хэлбэрээр эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилт тавьж, Монгол Улсын далбаа мандуулсан хөлөг онгоцоор далай ашиглах үйл ажиллагаа эрхлэх гадаад улсын иргэн, аж ахуй нэгж, байгууллагад улсын харьяалал, өмчийн төрөл, хэлбэрээс үл хамааран үйлчлэхийг тусгахаар зорьж байгаа нь Далай ашиглах тухай хуулийн зорилт, үйлчлэх хүрээ, харилцаа, зохицуулалтаас илүү өргөн хүрээний агуулгатай болно.

Мөн далай ашиглах үйл ажиллагаа эрхлэхэд манай улсын төрийн болон төрийн бус байгууллагууд, Улсын Их хурал, Засгийн газар, холбогдох яамдуудын энэ салбарт хэрхэн уялдаа холбоотой хамтран ажиллах, Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага далай ашиглах үйл ажиллагаа эрхлэхдээ олон улсын хэмжээний харилцаанд хэрхэн оролцох асуудлуудыг зохицуулна.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улс далайд гарцгүй орны хувьд далайн эрэг бүхий орны нэгэн адил конвенциор олгогдсон эрхээ бүрэн эдэлж, гадаад далайд гарч өөрийн улсын экспортын болон импортын бүх төрлийн ачаа барааг хөлөг онгоцоор тээвэрлэн далайн олон улсын худалдаа, тээврийн үйл ажиллагаанд оролцох, далайн баялагийг ашиглах таатай орчин бүрдэнэ.

Түүнчлэн, энэ салбарт Монгол Улсад ашигтай хэд хэдэн чиглэлээр төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд үйл ажиллагаа явуулах үндэс суурь бий болж манай улсын төсөвт орох ашиг орлого нэмэгдэх боломжтой юм. Тухайлбал, далайн тээвэр хийх, далайгаас загас агнуур эрхлэх, далайн баялаг олборлох, судалгаа шинжилгээ хийх, хөлөг онгоцны бүртгэлийг өргөжүүлэн ажиллах гэх мэт.

Хуулийн төсөл батлагдсаны дараа далайн тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эхлэн бусад холбогдох яамдуудтай хамтран далай ашиглах үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбогдсон дүрэм, журам боловсруулах, олон улсын эрх бүхий байгууллагууд болон гадаад орнуудтай гэрээ хэлэлцээр хийх бэлтгэл ажлуудыг эрчимжүүлж, төрийн байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг эхлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Дээрхи арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсний үндсэн дээр Засгийн газар, Улсын Их Хуралд танилцуулж холбогдох чиглэл, шийдвэрүүдийг гаргуулна.

Мөн төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны уялдаа холбоог хангаж, үндэсний далайчдыг сургаж бэлтгэх, ажлын байр шинээр бий болгох, гадаад улсын хөлөг онгоцыг дангаар болон хамтран түрээслэх замаар тэднийг далай ашиглах үйл ажиллагааны зохих дадал туршлагатай болгож, цаашид манай улс өөрийн хөлөг онгоцтой болж далайн олон улсын худалдааны тээврийн үйл ажиллагаанд оролцох боломжийг бүрдүүлнэ. Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааг олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэн өргөжүүлэн, зохих түвшинд эрхлэн явуулах нь улсын төсөвт орох орлогыг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төслийн талаар

“Далай ашиглах тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд нийцэх байгаа бөгөөд шинээр Монгол Улсын бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага гарахгүй байна.

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ